

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2022 ОНЫ 04 ДУГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ  
/ЦАХИМ/ ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 04 дугээр сарын 15

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээг үй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	<b>Үүрэг, даалгавар-НЭГ:</b> Хөрөнгө оруулалтын ажлыг бүх шатанд эрчимжүүлж, зураг төсөв, ажлын даалгаваргүй ажлуудыг шуурхай шийдвэрлэж холбогдох байгууллагуудад хүргүүлж ажиллах.			
1.	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/140 дугаар захирамжаар дүүрэгт эрх шилжих ирсэн нийт 3 ажил байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Чандмань овооны тохижилт /14 дүгээр хороо/” - 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдөр тендер зарлагдсан, 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр нээнэ.</li> <li>2. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил – 1 /ЧД/ 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр тендер зарлагдсан, 2022 оны 05 сарын 09-ний өдөр нээнэ.</li> <li>3. Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажлын зураг төсөл боловсруулах /ЧД/ – дүүргийн Худалдан авах ажиллагааны албанад 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 3/772 дугаар албан бичгээр зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг хүргүүлсэн.</li> </ol> <p>Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд улс, нийслэл, дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 87,035.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 58 төсөл, арга хэмжээ, он дамжин хэрэгжих 101,273.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 112 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бэлтгэл ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 33,</li> <li>- Тендерийн шатандаа байгаа төсөл арга хэмжээ – 56,</li> <li>- Гэрээ байгуулагдан ажил хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 67,</li> <li>- Ажил 100 хувь хийгдэж дууссан – 14</li> </ul> <p>Тус дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд ажлын гүйцэтгэл удаашралтай, ашиглалтад өгөх хугацаа хэтэрсэн, барилгын норм, чанар стандарт зөрчсөн, зураг төсөв холбогдох тооцоо судалгаа хангалтгүй барилга, байгууламжид хяналт шалгалт хийх ажлын хэсэг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 10 дугаар захирамжаар байгуулагдсан. Тус ажлын хэсэг нь нийт 6 төсөл, арга</p>	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	50

	хэмжээний гүйцэтгэлийн явцтай 04 дүгээр сарын 22-ны өдөр болон 05 дугаар сарын 04-ны өдөр хяналт, шалгалт хийх хуваарийн төслийг гаргаад байна.  - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Цагаантолгойн нуур” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа “Автобусны буудлын тохижилт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/” төсөл арга хэмжээний хүрээнд 19 автобусны буудлын тохижилт хийгдэхээс 4 автобусны буудлын тохижилтын байршил стандарт шаардлага хангахгүй байсан тул Хот байгуулалт, хөгжлийн газарт 2/708 тоот албан бичгээр шинээр 4 байршилд ажлын даалгавар гаргуулахаар хүсэлт хүргүүлээд байна.			
<b>Үүрэг, даалгавар ХОЁР:</b> Дүүргүүд төсвийн орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлж, тодорхой үр дүнд хүрэхүйц ажлуудыг зохион байгуулж ажиллах.				
2.	Төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах зорилгоор 446 татвар төлөгчийн 28.7 тэр бум төгрөгийн өрөнд татвар төлөх нэхэмжлэх, 58 татвар төлөгчийн 3.5 тэрбум төгрөгийн өрөнд дансны хаалт хийж ажилласан байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
<b>Үүрэг, даалгавар ГУРАВ:</b> Нийслэлийн Татварын газраас орлого бүрдүүлэх ажлын хүрээнд дүүргүүдийн Татварын хэлтсүүдийг нэгдсэн удирдлагаар хангаж, орлого бүрдүүлэх тусгай удирдамж гарган нийслэлийн хэмжээнд орлого бүрдүүлэх ажлаа эрчимжүүлэх./				
3.	Дүүргийн Засаг даргын тамгын газар, дүүргийн Татварын хэлтэс, Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа зах худалдааны төвүүдийн удирдлагуудтай 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр уулзаж татвар төлөгчийн мэдээллийг багтаасан цахим төлбөрийн баримт буюу QR код бүхий наалтыг байршуулах мөн Ибаримт олголтын талаар мэдээлэл хийж ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<b>Үүрэг, даалгавар ДӨРӨВ:</b> Энэ сардаа багтаан орлогын тасалдлыг нөхөж, төсвийн орлогын гүйцэтгэлийг хангаж ажиллах.				
4.	2022 оны нэг дүгээр улиралд нийслэлд төвлөрүүлэх 12.1 тэр бум төгрөгийн орлогын гүйцэтгэлийг бүрэн хангаж ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
<b>Үүрэг, даалгавар ТАВ:</b> Эрх шилжүүлсэн болон захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллагууд хөрөнгө оруулалтын ажлын хүрээнд салбар бүрд шаардлагатай байгаа бараа, материал, тоног төхөөрөмжийн жагсаалтыг гүйцэтгэг аж ахуйн нэгж, байгууллагын нэртэй нь хамт гаргаж Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлж, тус газраас жагсаалтыг нэгтгэн, танилцуулах.				
5.	Тус үүрэг даалгаврын хүрээнд Нийслэлийн Өмчийн харилцааны газраас Засаг даргын захирамжаар эрх шилжүүлсэн болон захиалагчийн хяналт тавьж буй ажлын БНХАУ-ын хил дээр хүлээгдэж байгаа бараа, материал, тоног төхөөрөмж, бусад хөрөнгийн мэдээллийг 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн дотор АЛБАН БИЧГЭЭР ирүүлнэ үү гэсний дагуу 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 3/724 тоот албан бичгээр холбогдох мэдээллийг хүргүүлж ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
<b>Үүрэг, даалгавар ЗУРГАА:</b> Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрт байгаа цэцэрлэгт хүрээлэн болон бичил цэцэрлэгүүдийн өнгө, үзэмжийг сэргээх, засварлах ажлыг зохион байгуулах.				

6.	Дүүргийн хэмжээнд нийт 64 бичил цэцэрлэг байгаа бөгөөд дүүргийн “Тохижилт үйлчилгээ ХХК”-тай хамтран бичил цэцэрлэгийн арчилгааг эхлүүлэн 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн байдлаар 13 цэцэрлэгийн хайс, хашлага, 8 цэцэрлэгийн цамхаг тоглоом, 11 цэцэрлэгийн сагсны шит засварласан байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<b>Үүрэг, даалгавар ДОЛОО:</b> 2022 оны 04 дүгээр сараас эхлэн Сүхбаатарын талбай дээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах, териин үйлчилгээг иргэдэд үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах.				
7.	- “Их хотын хавар-2022” арга хэмжээний хүрээнд Сүхбаатарын талбайд дүүргийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нийт 24 иргэн, аж ахуйн нэгж байгууллага 11 асарт нийт 70 нэр төрлийн 350 бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлан, хямдралтай үнээр худалдаалж 8.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. - 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр дүүргийн Хүүхдийн номын өргөө, “Улаанбаатар Эрдэм” их сургууль өөрийн үйл ажиллагааны талаар болон элсэлтийн талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулж, нийт 186 хүнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
<b>Үүрэг, даалгавар НАЙМ:</b> Өнөөдөр 14.00 цагаас Монголын хүүхдийн ордонд зохион байгуулагдах “Авилгын эсрэг нийслэлийн зөвлөгөөн” нийслэлийн Удирдах албан тушаалтууд бүгд оролцох.				
8.	2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан “Авилгын эсрэг нийслэлийн зөвлөгөөнд” дүүргийн Засаг дарга, Засаг даргын Дэд бүтэц тохижилтын асуудал хариуцсан орлогч, Засаг даргын Тамгын газрын дарга, Хэлтэс албадын дарга нар бүрэн хамрагдсан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
<b>Үүрэг, даалгавар ЕС:</b> Хаврын хуурайшилтын үед ой хээрийн түймэр болон объектын гол түймрээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж ажиллах.				
9.	Дүүргийн нутаг дэвсгэрт ой, хээрийн гол түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн Онцгой комиссын даргын 2022 оны “Ой, хээрийн гол түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгавар, захирамжийг 2022 оны 13.10/124 дугаартай албан бичгээр Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Тохижилт үйлчилгээний хэлтэс, Ногоон бүсийн 17, 19 дүгээр хороодын Засаг дарга нар болон бусад хэлтэс албадын дарга нарт хүргүүлсэн мөн ногоон бүсэд оршин сууж буй 412 айл өрхөд өөрийн болон нийтийн эзэмшлийн зам талбайд өнжмөл шар өвс шатаахгүй байх, гол түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах тухай Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн баталгааны хуудас, зөвлөмж, мэдэгдэл зэргийг хүргүүлэн ажилласан.  Ой, хээрийн гол түймэр унтраах багаж зэвсэглэмжийн бэлэн байдлыг хангах хүрээнд үлээгч аппарат 30, зөөврийн ус шүршигч /рло/ 24, трессон шүүр 180, цохиур 150, хүрз 80, сүх 10, хөрөө 12, цуравдагч 8, зөөврийн гэрэл, мотортой 1 ширхэг зэрэг бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэн ажиллалаа.			100

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, голомтод ажиллах 12 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй 1 бүлгийг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн даргын 2022 оны А/15 дугаар тушаалаар томилгоожуулан ногоон бүсийн 17 дугаар хороо Чингэлтэй хайрхан, Зүрх-уул, Залаатын ам, 19 дүгээр хороо Шадивлан, Яргайт, Жигжид /моби/, Жигжид /араанзат/, Жигжид /гүнт/, Майхан толгой, Санзай, Халзангийн даваа зэрэг амуудад хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэн ногоон бүсэд нэвтэрч алхалт хийж буй нийт 1518 иргэнд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмж өгч 1485 ширхэг санамж сээрэмжлүүлгийн материал өгч ажилласан.

ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Н.ХАНГАЙ

ХЯНАСАН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
ДАРГА

М.НАВЧАА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

У.МАГНАЙ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДОЛГОРМОАА